

COMPREHENSIVE COMPETENCY-BASED TRAINING TECHNOLOGY AND HUMAN RESOURCE POLICY ISSUES

ЦОГЦ ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ТЕХНОЛОГИ БА ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН АСУУДАЛД



Б.ОДОНЧИМЭГ

ХСИС-ийн Сургалтын хэлтсийн Багшийн хөгжил, мэргэшүүлэх сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад

ODONCHIMEG B.

Senior officer of Lecturer development and professional training in Academic training division, police captain

Товч утга: Хууль сахиулах салбарын хүний нөөцийг чадварлаг, шилмэл бүрэлдэхүүнээр хангах нь манай сургуулийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг. Манай төгсөгчид шилмэл байх эсэх нь боловсролын болон хууль сахиулах салбарын шинжлэх ухааны орчин үеийн онол, арга зүйд тулгуурласан сургалтын технологийн оновчтой сонголтоос шалтгаална. Сургалтын технологийг олон талт, шинжлэх ухаанч шийдлээр сонгох боломжийг нэмэгдүүлэх зорилгоор (POP) буюу асуудалд чиглэсэн цагдаагийн ажлын онол арга зүйг сургалтын технологид нэвтрүүлэх талаар боловсруулсан саналыг танилцуулж байна.

Abstract: The main function of the Law Enforcement University is to enhance the human resources of Law Enforcement sector with highly skilled, educated and qualified staff. The excellence of our graduates depends on the right selection of educational technology based on cutting-edge theory and methodology in educational and law enforcement fields. In order to scientifically select the optimal educational technology, I am introducing a new technology-the problem-oriented policing into the training.

Түлхүүр үгс: Хууль сахиулахын тухай ойлголт, хууль сахиулах мэргэжил, ЮНЕСКО ангилал, хууль сахиулахын цогц чадамж, хууль сахиулахын боловсролын сургалтын үзэл баримтлал, хууль сахиулахын их сургуулийн сургалтын технологи.

Key words: The concept of law enforcement, the law enforcement profession, UNESCO category, comprehensive competency on law enforcement, the concept of law enforcement education, training technology at Law Enforcement University.

Тактикгүй стратеги нь ялалтад хүрэх тойруу зам,
стратегигүй тактик нь сүйрлийн өмнөх бужигнаан.

Сун Ци

Шинжлэх ухааны ололт нээлт, техник технологийн шинэ дэвшлүүд байнгын өөрчлөлт, шинэчлэлтийг тулгаж байгаа цаг үед бид тогтвортой хөгжих тулгуур чиг хандлагаа тодорхойлсноор үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах, хууль хэрэгжүүлэх ажлыг инновацийн үр ашигтай тогтолцоогоор хөгжүүлэн олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт манлайлагч, мэдлэг, оюуны төв байх алсын хараагаа хэрэгжүүлэх боломжтой болно.

Сүүлийн жилүүдэд өөрчлөлт, шинэчлэлт амьдралын бүхий л салбар, түвшинд нөлөөлж байгааг бидний хөдөлмөрлөж буй салбарын нөхцөл байдал харуулж байна. Их сургууль 2011 оноос хойш өнөөдрийг хүртэл нэрээ 2 удаа, бүтэц зохион

байгуулалтаа 4 удаа шинэчилсэн байдаг. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 229 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийг нэгтгэн Дотоод хэргийн их сургууль, Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 87 дугаар тогтоолоор ДХИС-ийг Хууль сахиулахын их сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан. Мөн одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хууль зүйн сайдын 2014 оны А/185 дугаар тушаалаар батлагдсан “ХСИС-ийн дүрэм”-ийн нэгдүгээр бүлгийн гуравдугаар зүйлийн 3.1-д “Их сургууль нь төрийн өмчид тулгуурласан, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай, эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн хэв шинж бүхий дээд боловсролын төрийн тусгай чиг үүргийн бие даасан байгууллага” гэж үйл ажиллагааны хэв шинжээ нарийвчлан тодорхойлсон байдаг.

Засгийн газрын дээрх тогтоолуудаар их сургуулийн хэв шинж бүхий үйл ажиллагаа явуулах эрх үүрэг хүлээж, 4 жилийн хугацаанд “Боловсрол, шинжлэх ухааны талаар баримтлах төрийн бодлогод тулгуурлан, боловсрол, эрдэм шинжилгээний ажлын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн хүмүүнлэг, ардчилсан, эрх зүйт нийгмийг зохион байгуулахад шударга ёсыг тогтоох бат итгэл үнэмшилтэй, мэргэжлийн өндөр боловсрол, ур чадвартай, ёс суртахууны бүрэн төлөвшилтэй төрийн тусгай алба хаагч бэлтгэх, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг хангах” зорилготойгоор ажиллаж ирлээ.

Ийнхүү тогтоол, тушаалаар их сургуулийн статусыг тогтоож, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтүүдийг удаа дараа хийж ирсэн ч эдгээр өөрчлөлтүүдийн үзэл баримтлал, чиг хандлага, шинжлэх ухааны үндэслэлүүд тодорхойгүй, зарим нэг агуулгад тунхагын шинжтэй тусгагдсан нь учир дутагдалтай.

Ийм тохиолдолд зорилгоо хангаж, эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн хэв шинжид нийцсэн үйл ажиллагаа хөтлөн явуулахын тулд бид өөрсдийн оролцоотойгоор дараах хэдэн асуудлуудыг цогц байдлаар, шинжлэх ухаанчаар судлан шийдэх шаардлагатай байна.

1. Улс орны өнөө болон ирээдүйн хөгжлийн төлөв, бодлого хөтөлбөрүүдийг үндэслэн их сургуулийн сургалтын үйл ажиллагааны үзэл баримтлал, технологийн шинэчлэл, багшийн хөгжлийн чиг баримжааг хууль сахиулахуйн тухай ойлголт, үзэл баримтлалтай уялдуулан тодорхойлох;

2. Хууль сахиулах салбарын хөгжлийн мөн чанар, чиг хандлагатай уялдуулан мэргэжилтний цогц чадамжийг тодорхойлох;

3. Хууль сахиулагчдын эзэмшвэл зохих цогц чадамжийг бүтээхүйц сургалтын болон хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, хичээлийн арга, сургалтын арга зүй, хууль сахиулахуйн боловсролын технологийг хөгжүүлэх;

4. Улмаар сургуулийн онцлогт нийцсэн үйл ажиллагааны хэв шинж, ХСИС-ийг хөгжүүлэх стратегийн зорилго, зорилтуудыг шинэчлэн тодорхойлж, хэрэгжүүлэх зэрэг болно.

Дээрх агуулгаар боловсрол судлалын болон хууль сахиулахуйн шинжлэх ухааны интеграци орчинд профессор багш, эрдэмтэн судлаачид судалгаа, шинжилгээ, сургалтын технологийн туршилт хийх нь боловсролын инновацийг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл, их сургуулийн тогтвортой хөгжлийн суурь болох юм.

Зураг 1. ХСИС-ийн сургалтын үйл ажиллагааны технологийг тодорхойлох үндэс



Юуны түрүүнд хууль сахиулахуйн талаар ойлголтыг ажил мэргэжлийн ангилал болон эрх зүй, хууль зүйн талаас нь хэрхэн авч үзэж байгааг харья.

Хууль сахиулах ажил мэргэжлийг Боловсролын олон улсын ангиллын стандарт (International standard classification of education “ISCED2013”)¹, Ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал (ISCO-08) зэрэг олон улсын эдийн засаг, хамтын ажиллагааны статистик боловсруулалтын баримт бичигтэй холбон авч үзвэл цагдаа, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, онцгой байдал, гадаадын иргэдийн асуудал, шүүх шинжилгээний ажил мэргэжлүүд нь үйлчилгээний салбарын, аюулгүй байдал хамгаалалтын үйлчилгээний төрөл мэргэжлийн, хууль сахиулах, аюулгүй байдлын нарийвчилсан мэргэжлийн ангилалд багтаж индекслэгдсэн байдаг.

Тухайн ангиллаар БСШУЯ дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл (хөтөлбөр), индексийг 2014 оны А/78 дугаар тушаалаар шинэчлэн баталсаны дотор Хууль сахиулахын их сургууль нь үйлчилгээний салбарын (10 services) аюулгүй байдал, хамгаалалтын төрөл мэргэжлийн (103 security services) иргэд ба тэдний өмч хөрөнгийн хамгаалалт (1032 protection of persons and property), Аюулгүй байдал хамгаалалтын төрлийн цэрэг, батлан хамгаалах болон иргэд, өмч хөрөнгийн хамгаалалтын хоорондын нарийвчилсан (1038 Inter-disciplinary programmes and qualifications involving security services) мэргэжлийн хөтөлбөрүүдийг индексжүүлсэн. Эдгээр индексийн хөтөлбөрөөр төгсөгчид нь олон улсын хэмжээнд судалсан агуулга, эзэмшсэн цогц чадамжаараа бусад улс орны хууль сахиулагчидтай ижил түвшинд хүлээн зөвшөөрөгдөх боломжтой болж байгаа юм.

Дээрх ангилал, индексүүдээр бол хууль сахиулах ажил мэргэжил нь иргэдэд аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх зориулалтаар олон улсад хүлээн зөвшөөрөгдөж байгааг харж болно.

Харин хууль сахиулахуйн философи үндэс, шинжлэх ухааны үндэслэл, үзэл баримтлалын талаар дорвитой судалгаа, шинжилгээ ховор бөгөөд хууль зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд зарим судлаач, мэргэжилтнүүд хууль сахиулах үйл ажиллагааны тодорхойлолт хэлбэрээр гаргасан байна. Энэ талаар манай судлаач Д.Булган “Хууль сахиулах ажиллагаа нь эрх зүйн хэм хэмжээг сахих, биелүүлэх, ашиглахад хяналт тавих үндсэн хэлбэр болох бөгөөд эдгээр хэлбэр биелэлээ олохгүй тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх байдлаар хуулийн биелэлтийг хянах, хангах явдал”² хэмээн тодорхойлсон нь хууль сахиулагчдын бүрэлдэхүүнд цагдаа, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, онцгой байдал, шүүх шинжилгээний мэргэжилтнүүд төдийгүй гааль, татвар, мэргэжлийн хяналт, байгаль орчны

¹ International standard classification of education “ISCED2013”

² Цагдаагийн байгууллагын хууль сахиулах инноваци, Д. Булган, 197 –р хуудас, Хууль сахиулахуйн инноваци олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2014 он

байцаагчид үйл ажиллагааны чиглэлээрээ хамрагдах боломжтой мэт.

Төрийн, нийтийн, нийгмийн, иргэний эрх ашгийн алийг нь хангаж, хамгаалах мэргэжилтэнг бэлтгэх вэ гэдэг нь хууль сахиулахуйн философийн буюу үзэл баримтлалын асуудал бөгөөд судалгааны нэгэн шинэ талбар юм.

Тухайн салбарын үйл ажиллагааны үзэл баримтлалаас шалтгаалан түүнийг хэрэгжүүлэгч мэргэжилтний цогц чадамж буюу асуудал шийдвэрлэх когнитив чадвар, түүнийг янз бүрийн нөхцөлд амжилттай, хариуцлагатай ашиглаж чадах социал чадвар, нийгмийн идэвхи, хүсэл, тэмүүлэл зэргийг тодорхойлно. ХСИС-ийн сургалтын хөтөлбөрүүдийн хөгжлийн явцад тухайн хөтөлбөрөөр олгох мэдлэг, чадварын жагсаалтыг тодорхойлох оролдлогууд хийгдэж ирсэн боловч Монгол Улсын стандартын түвшинд боловсруулагдаагүй л байна.

Манай улсын хувьд ажил мэргэжилд тавих шаардлага, ур чадварын жагсаалт хараахан гараагүй ч их дээд сургууль, коллежуудын туршлага болохуйц санаачлагууд байдгийн нэг нь АШУҮИС, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яамтай хамтран “Эрүүл мэндийн зарим мэргэжлээр төгсөгчид тавих шаардлага”-ыг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2012 оны 102 дугаар тушаалаар батлуулан сургалтын үйл ажиллагааны зорилт болгон ашиглаж байна.

Олон улсад хууль сахиулагчид, түүн дотроо цагдаагийн ажилтнуудын мэдлэг, чадвар, хандлагад тавих шаардлагын жагсаалтыг төрөл бүрийн хэлбэрээр гаргасан байна. Тухайлбал, ОХУ-д Хууль сахиулахуйн бакалаврын хөтөлбөрийн стандартдаа (ФГОС³) ерөнхий 16 цогц чадамж, мэргэжлийн 39 цогц чадамж эзэмшүүлэхээр заасан бол Их британи, Умард Ирландын нэгдсэн Вант улсад Цагдаагийн хөгжлийн үндэсний товчооноос NPIA (National Policing Improvement Agency) цагдаагийн мэргэжлийн хүрээг (Policing Professional Framework PPF) Төрийн үйлчилгээний чадвар, Мэргэжлийн чадвар, Манлайллын чадвар, Шийдвэр гаргах чадвар, Бусадтай хамтран ажиллах чадвар, Хувийн чанар зэрэг үзүүлэлтээр албан тушаалын зэрэг бүрээр⁴ тодорхойлж, Үндэсний мэргэжлийн стандартаар (NOS)⁵ баталгаажуулжээ.

Зураг 2. Их британи, Умард Ирландын нэгдсэн Вант улсын хууль сахиулагчдад тавигдах чадварын загвар

	Public service	Profes- sionalism	Leadership			Deci- sion making	Work- ing with others
Executive	Serving the public	Profession- alism	Leading strategic change	Leading the work- force	Man- aging perfor- mance	Decision making	Working with others

³ Министерства образования и науки Российской Федерации от 14 января 2011 г. N 20 Федеральный государственный образовательный стандарт высшего профессионального образования по направлению Подготовки (специальности) 031001 правоохранительная деятельность (квалификация (степень) “специалист”)

⁴ Policing Professional Framework Personal Qualities, <https://www.skillsforjustice.ppf.com/>

⁵ National Occupational Standards (NOS) <http://nos.ukces.org.uk/PublishedNos/SFJC1105.pdf#search=Po-licing>

	Public service	Professionalism	Leadership			Decision making	Working with others
Senior manager	Serving the public	Professionalism	Leading change	Leading people	Managing performance	Decision making	Working with others
Middle manager	Serving the public	Professionalism	Leading change	Leading people	Managing performance	Decision making	Working with others
Supervisory manager	Serving the public	Professionalism	Leading change	Leading people	Managing performance	Decision making	Working with others
Practitioner	Serving the public	Professionalism	Openness to change	Service delivery		Decision making	Working with others

Ийнхүү дээд боловсролын тогтолцоог цогц чадамжид суурилсан хандлагаар хөгжүүлж байгаа нь тогтворгүй, урьдчилан таашгүй өөрчлөлтийн орчинд тогтвортой хөдөлмөрлөх чадамжтай төгсөгчдийг бэлтгэн гаргах үндэс болж байна. Мэргэжилтнийг мэргэшүүлэх уламжлалт хандлага нь ажлын байрны шаардлага болон сургалтын зорилгын хамаарлыг үүсгэж, суралцагчдад стандартчилсан мэдлэг, чадвар, дадал олгохоор сургадаг байсан бол цогц чадамж нь суралцагчдад хөдөлмөрийн олон талт, ярвигтай нөхцөлд чиг баримжаагаа олж, өөрийн үйл ажиллагааны үр дагаврыг тооцоолон хариуцлага хүлээн бие даан ажиллах чадварыг хөгжүүлэхэд чиглэдэг.

Цогц чадамжийн тухай ойлголтыг анх америкийн хэл шинжлэлч Н.Хомский өөрийн судалгаандаа ашиглажээ. Тэрээр "...Бид хэлний чадамж (өөрийн хэлээр ярьж, сонсох) болон хэрэглээний (хэлийг тодорхой нөхцөлд бодитой ашиглах) хоорон дахь суурь ялгааг судалж байна. Зөвхөн хамгийн тохиромжтой нөхцөлд л хэрэглээ нь чадамжийн илэрхийлэл болж чадна..." гэдгийг тодорхойлжээ. Н.Хомский болон бусад судлаачдын оролцоотойгоор чадамж гэдэг ойлголтыг 1960–1970 онуудад шинжлэх ухааны судалгаанд хэрэглэж, 1970–1990 онуудад хэл шинжлэл, удирдлага, менежментийн шинжлэх ухааны онол, арга зүйн хэрэгсэл болгож эхэлсэн.⁶ Ялангуяа Р.Уайт (1959) "Motivation reconsidered: the concept of competence" сэдэвт бүтээлдээ чадамжийн тухай ойлголтыг бие хүний сэдэл, сэдэлжилттэй холбон тайлбарлаж, Ж. Равен (1984) "Компетентность в современном обществе" бүтээлдээ "Чадамж нь танин мэдэхүй, сэтгэл хөдлөлийн шинжтэй олон чадваруудаас бүрдэж, зохист зан үйлээр илэрнэ." хэмээсний зэрэгцээ сэдэлжсэн чадвар бол чадамжийн мөн чанар гэж тодорхойлон уг ойлголтыг бие хүний төлөвшилттэй холбон баяжуулжээ.

Боловсролын салбарт цогц чадамжийн ухагдахууныг хэрэглэсэн нь 1997 онд "Европын бүс нутаг дахь дээд боловсролын мэргэжлийн ур чадварыг хүлээн зөвшөөрөх" Лиссабоны конвенцийн үед төгсөгчдөд тавих нийтээр хүлээн зөвшөөрөхүйц төрөл бүрийн шаардлагуудыг багцалснаас эхтэй. Орчин үеийн

⁶ См. Зимняя И.А. Ключевые компетенции - новая парадигма результата образования // Высшее образование сегодня, 2003. № 5. С. 34-42.

шинжлэх ухаан технологи, нийгэм, эдийн засаг, соёлын хөгжил нь их дээд сургууль төгсөгчдөд улам бүр шинэ шаардлагууд тулгаж байгаагийн үндсэн чиглэл нь оюун санаа, харилцаа, ёс зүй, хувийн зохион байгуулалт зэрэг бие хүн аливаа үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх нэгдмэл тогтолцоот чанар буюу цогц чадамж юм. Энэ шаардлагын утгыг ЮНЕСКО-гийн илтгэлд: “Ажил олгогчдод зөвхөн тодорхой үйлдэл хийх чадвараас илүү бусадтай хамтран ажиллах, санаачилга гаргах, эрсдэлд бэлэн байх тийм дадал, хандлагын цогц төлөвшил чухал хэрэгцээтэй болсон...”⁷ гэж тэмдэглэсэн.

1989 оноос эхэлсэн европын орнуудын боловсролын тогтолцоог нэгдмэл болгох, их дээд сургуулиудын багц цаг, дүн, үнэлгээг нэг томъёололд оруулан харилцан хүлээн зөвшөөрөх зорилготой Болонийн үйл явцын үеэр боловсролын эцсийн үр дүнг тодорхойлох бодит шаардлагад нийцсэн цогц чадамжид тулгуурласан сургалтын технологийн ойлголт хөгжиж, улмаар сургалтын үйл ажиллагааг олон шатлалт, шугаман бус байдлаар хувь хүний онцлогтой уялдуулан төлөвлөх, үр дүнг хуримтлуулсан болон шилжүүлсэн нэгжээр тооцох боломжтой багц цаг-модулийн тогтолцоонд шилжүүлэх үзэл баримтлал бий болсон байна.

Үүнтэй уялдан TUNING⁸ төслийн хүрээнд Болонийн тунхаглалын зорилгыг тогтолцооны хэмжээнд хэрэгжүүлэх чиглэлийг цогц чадамжид тулгуурлан ерөнхий болон мэргэжлийн чадамжийн хүрээгээр боловсруулжээ. Ерөнхий чадамжид дараах чадваруудыг багтаасан. Үүнд:

- Танин мэдэхүйн буюу утга санааг ухаарч хэрэглэх, орчин тойрноо ойлгож чиглүүлэх, цаг хугацааг зохион байгуулах, суралцах хэтийн зорилгоо тодорхойлох, асуудал тодорхойлж, шийдвэр гаргах, харилцах зэрэг чадварууд

- Хүмүүс хоорондын харилцааны (межличностные) чадамж буюу мэдрэмж, хандлагаа илэрхийлэх, өөртөө болон бусдад шүүмжлэлтэй хандах, хамтран ажиллаж амьдрах, нийгмийн болон ёс зүйн үүрэг хүлээх зэрэг чадварууд

- Тогтолцооны чадамж буюу мэдлэг, чадвар, хандлагаа хослуулан ашиглаж орчин тойрноо төгөлдөржүүлэх, шинэ тогтолцоог загварчлах, шинээр бүтээх чадваруудыг багтаан тодорхойлсон.

Дээрх ойлголт, тодорхойлолтуудаас чадамж бол амьдрал, үйл ажиллагааны хувьсан өөрчлөгдөх нөхцөлд мэдлэг, чадвараа хэрэглэх туршлага, ажил үүргээ гүйцэтгэх хүсэл эрмэлзлэл, аливаад хандах эерэг хандлагыг бүхэлд нь хамарсан бие хүний нэгдмэл чанар бөгөөд мэдлэг, мэдлэгийн хүрээгээр хязгаарлагдахгүй ойлголт гэдэг нь харагдлаа.

Цогц чадамж нь ХСИС-ийн төгсөгчдөд болон хууль сахиулах байгууллагын мэргэжилтэнд тавих шалгуурыг нэгдмэл байдлаар ойлголцон хамтран боловсруулахад үндсэн шугам болж чадахуйц хэрэгсэл тул хууль сахиулагчдын цогц чадамжийг ерөнхий болон мэргэжлийн чиглэлээр албан тушаалын ангилал, мэргэжилтэн бие хүний хөгжлийн үе шаттай уялдуулан боловсруулах нь хууль сахиулах салбарт шинэчлэлийг шинжлэх ухааны үндэстэйгээр жинхэнэ утгаар нь авч ирэх томоохон ажил юм.

Өөрөөр хэлбэл, цогц чадамж нь хууль сахиулах салбарын хүний нөөцийн бодлогын үндэс бөгөөд бүрдүүлэлт, хөгжүүлэлт, үнэлгээ, урамшууллын суурь үзүүлэлт юм. Судалгааны энэ талбар мөн л судлаачдыг хүлээсээр...

Нэгэнт тодорхойлсон цогц чадамжийг бүтээхүйц боловсролын технологи,

⁷ Доклад международной комиссии по образованию, представленный ЮНЕСКО «Образование: сокрытое сокровище». — М.: ЮНЕСКО, 1997.

⁸ TUNING educational structures in Europe (Настройка образовательный структур в Европе)

сургалтын арга зүйг хууль сахиулах салбарын хөгжлийн чиг хандлага, үзэл баримтлалтай нийцүүлэн сонгох эсвэл боловсруулан хэрэглэх асуудал ч судалгаа нэхсэн хэвээр.

Монгол Улсын төрийн өмчийн их дээд сургуулиуд дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд боловсролын үзэл баримтлал, технологидоо цогц чадамжид үндэслэсэн шинэ арга зүйг нэвтрүүлэн хэрэглэж, улмаар сургалтын хөтөлбөрүүдээ олон улсад магадлан итгэмжлүүлж, дэлхийн тавцанд өрсөлдөх алхамаа хийсээр байна. Тухайлбал, ШУТИС, АШУҮИС, МУБИС зэрэг их сургуулиуд олон улсын мэргэжлийн холбоод, тэргүүлэх их сургуулиудын боловсруулсан дараах сургалтын технологи, хичээлийн арга зүйг нутагшуулж эхэллээ.

Хүснэгт 1. Цогц чадамжид суурилсан технологи хэрэгжүүлэгч сургуулиудын жишээ

№	Сургуулийн нэр	Технологийн нэр	Суурилсан цогц чадамж	Санаачлагч, хамтрагчид
1	ШУТИС	CDIO—(conceiving designing implementing operating)	Олон улсын инженерийн боловсролын цогц чадамж	Massachusetts Institute of Technology, Swedish universities - Chalmers University of Technology, Linköping University and the Royal Institute of Technology
2	АШУҮИС	PIS (problems information solutions)	Эрүүл мэндийн сайдын 2012.4.02 №102 тушаал “Эрүүл мэндийн зарим мэргэжлээр төгсөгчид тавих шаардлага”	Канад улсын Калгарийн Их Сургууль
3	МУБИС	PLO (program learning outcome)	(ICT Competency Standards for Teachers, ICT-CST), бие хүний сурах үйл ажиллагааны сэтгэл зүйн үндэслэлтэй холбон боловсруулсан.	ЮНЕСКО

Хууль сахиулах салбарын мэргэжилтэн бэлтгэх шилдэг технологи, арга зүй олон улсын хэмжээнд хэрхэн хэрэгжиж байгааг судалж байх явцад АНУ-ын Висконсин-Мэйдисоны их сургуулийн профессор Герман Гольдштейний боловсруулсан асуудалд чиглэсэн цагдаагийн ажиллагаа буюу Problem-oriented policing (POP) стратеги анхаарал татсан юм. Энэ хандлагын гол мөн чанар нь “...гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд гэмт хэрэгтнийг бариад, яллах төдийгөөр ажиллах биш, гэмт хэргийн гаралтыг уг язгуураар нь бууруулахад чиглэсэн асуудлыг тодорхойлж, санаачлага, оролцоотой ажиллах явдал.”⁹ Өөрөөр хэлбэл, асуудлыг эрэн хайж, шинжлэн судалж тодорхойлон гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төр, хувийн хэвшил, олон нийтийн оролцоог хангах явдал юм. POP загварыг хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд АНУ-ын Нью-Йорк мужийн улсын их сургуулийн харьяа Олбанигийн их сургууль, Висконсины их сургуулийн профессор багш, эрдэмтэн судлаачид тэргүүлэх үүрэг гүйцэтгэсэн байдаг.

Тухайлбал, 1979 онд Гольдштейны загварыг Джон Е. Эк өргөжүүлэн баяжуулж, 1987 онд Уильям Спелман асуудал шийдвэрлэх SARA аргыг бүтээсэн. Цогц чадамжид тулгууран асуудалд чиглэсэн POP технологи, SARA арга зүйд үндэслэсэн сургалтын

⁹ POP <http://www.popcenter.org/>

хөтөлбөрийг боловсруулж ашиглаж байгаа Australian Institute of Criminology, Center for Court Innovation, Center for Homicide Research, Community Oriented Policing Services (COPS), Design Against Crime (DAC) Research Centre (UK), Home Office Crime Reduction (UK), International Association of Chiefs of Police, International Association of Crime Analysts, International Centre for the Prevention of Crime (Canada), International CPTED Association, Jill Dando Institute of Crime Science, Local Initiatives Support Corporation (LISC), National Crime Prevention (Australia), National Criminal Justice Reference Service, National Institute of Justice, Police Executive Research Forum (PERF), Police Foundation, Police Society for Problem-Based Learning зэрэг сургалтын байгууллагууд байна.

ХСИС ч эдгээр сургууль, байгууллагатай сургалтын технологи, хөтөлбөрийн чиглэлээр хамтран ажиллаж хууль сахиулагчдын цогц чадамж, сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулах боломжтой.

Санал, дүгнэлт

1. ХСИС-ийн төгсөгчдөд болон хууль сахиулах байгууллагын мэргэжилтэнд тавих шалгуурыг цогц чадамжийн түвшинд ерөнхий болон мэргэжлийн чиглэлээр албан тушаалын ангилал, мэргэжилтэн бие хүний хөгжлийн үе шаттай уялдуулан боловсруулж, ХЗЯ-аар батлуулах;

2. Асуудал шийдвэрлэх сургалтын технологи нэвтрүүлэх, олон улсын түвшинд нийцсэн сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлээр гадаадын ижил төстэй их дээд сургуулиудтай хамтран ажиллах;

3. Хууль сахиулах салбарын агентлаг байгууллагуудтай салбарын хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, хөгжүүлэлтийн асуудлаар суурь судалгаанд үндэслэсэн бодлогын шинжтэй төсөл хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах;

4. Хууль сахиулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж мэргэжилтнүүдэд (төрөл бүрийн хяналтын байцаагчид) хууль сахиулахуйн суурь мэдлэг, чадвар олгох мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх зэрэг саналтай байна.

Эх сурвалжийн жагсаалт.

1. Зимняя И.А. (2006) Ключевые компетенции - новая парадигма результата образования Интернет-журнал Эйдос- 2006 -5 мая. <http://www.eidos.ru/journal/2006/0505.htm>.

2. Булган. Д (2014) Цагдаагийн байгууллагын хууль сахиулах инноваци. Хууль сахиулахуйн инноваци олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 197

3. UNESCO Institute for Statistics. ISCED Fields of Education and Training 2013. Retrieved from <http://www.uis.unesco.org/Education/Documents/isced-fields-of-education-training-2013.pdf>

4. National Policing Improvement Agency. Policing Professional Framework Personal Qualities. Retrieved from <https://www.skillsforjustice.ppf.com/>

5. National Occupational Standards (NOS). Retrieved from <http://nos.ukces.org.uk/>

Pages/index.asp

6. Center for Problem-Oriented Policing. Begin the What is POP Module. Retrieved from <http://www.popcenter.org/>

7. TUNING. Educational structures in Europe Retrieved from http://www.uc.pt/ge3s/event_04/event_04/tuningexecutivesummary-3.pdf

8. Федеральный государственный образовательный стандарт высшего профессионального образования по направлению: Подготовки (специальности) 031001 правоохранительная деятельность (квалификация (степень) "специалист" Министерства образования и науки Российской Федерации от 14 января 2011 г. N 20 Retrieved from <http://xn--80abucjiibhv9a.xn>

9. М.: ЮНЕСКО. Доклад международной комиссии по образованию, представленный ЮНЕСКО «Образование: сокрытое сокровище» 1997. : <http://www.ifap.ru>